

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
500 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсан./*

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар
сарын 25 -ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт

ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Даатгагч Даатгалын тухай хуульд заасан даатгагчийн баталгаа (цаашид “баталгаа” гэх) гаргах үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Даатгагч Даатгалын тухай хуулийн 6¹.1 дэх хэсэгт заасан баталгааг гаргаж болно.

Хоёр.Баталгаа гаргах үйл ажиллагаанд тавигдах шаардлага

2.1.Даатгагч баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.даатгагч баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тухай шийдвэрийг эрх бүхий этгээдээс гаргасан байх;

2.1.2.дараах харилцааг тусгасан баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр батлуулсан байх:

2.1.2.1.баталгаа гаргах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, шийдвэрлэх, түүнд хяналт тавих тухай;

2.1.2.2.баталгаатай холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, удирдах, бууруулах арга, аргачлалыг багтаасан эрсдэлийн удирдлагын бодлого;

2.1.2.3.үүрэг гүйцэтгэгчийг таньж мэдэх аргачлал (үүрэг гүйцэтгэгчийн санхүүгийн чадавх, хүний нөөц, ажлын туршлага болон ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж зэрэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хангалттай эсэх);

2.1.2.4.баталгаа гаргах үйл ажиллагаатай холбоотой шимтгэлийн хувь хэмжээг тооцох, баталгааны нөөц сан байгуулах шалгуур үзүүлэлт, аргачлал;

2.1.2.5.баталгаа гаргах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүдэд тухай бүр хүргүүлж, тайлагнах тухай;

2.1.3.баталгаа гаргах үйл ажиллагааг хариуцсан бие даасан нэгжтэй байх;

2.1.4.“Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д

заасан шаардлагад нийцүүлэн баталгааны нөөц сан байгуулах хувь хэмжээг ТУЗ-өөр батлуулсан байх.

2.2. Даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ нь даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнгийн 70 хувиас хэтрэхгүй бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$ДБ=ДӨХ*70\%$$

ДБ – даатгагчийн өөрт үлдээх баталгааны дээд хэмжээ

ДӨХ – даатгагчийн өөрийн хөрөнгийн дүн (“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 2.3, 2.4, 2.5 дахь хэсэгт заасан өөрийн хөрөнгийн дүн)

2.3. Даатгагчийн ТУЗ нь санхүү, төлбөрийн чадварын байдлаа харгалзан баталгааны эрсдэлийг үнэлж, тухайн жилд гаргаж болох баталгааны нийт хэмжээг энэ журмын 2.2, 2.7-д заасан хязгаарт нийцүүлэн жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

2.4. Даатгагч энэ журмын 2.3-г заасан шийдвэрийг батлагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор, уг шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд үндэслэл, шаардлага, тооцооллыг тухай бүр Хороонд ирүүлнэ.

2.5. Даатгагч баталгаа гаргах тухай бүрд дараах шаардлагыг хангана:

2.5.1. Өмнөх тайлант үед “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-д заасан даатгагчийн төлбөрийн чадварын нэгдүгээр, эсвэл хоёрдугаар түвшинд байх;

2.5.2. Баталгааны нөхцөл, үнэ нэмэгдсэн, өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран баталгаа нь тухайн гэрээний нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байх;

2.5.3. “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу баталгааны нөөц санг байгуулах.

2.6. Баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх даатгагч нар хамтран баталгааны гэрээний нийтлэг загвар гаргах, мэдээллийн нэгдсэн сан болон хамтын эрсдэлийн санг байгуулах, удирдах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий тухайн даатгагч нарын гишүүнчлэлээс бүрдсэн хамтын удирдлагын бүтцийг бий болгоно.

2.7. Даатгагчийн гаргах баталгааны нийт хэмжээ энэ журмын 2.2-т заасан хэмжээнээс давсан бол эрсдэлийн үнэлгээ хийж, тухайн давсан хэсгийг давхар даатгуулна.

2.8. Давхар даатгагчийн хувьд энэ журмын 2.2 дахь хэсэг хамаарахгүй.

Гурав. Баталгааны бүртгэл, тайлан, мэдээлэл

3.1. Даатгагч баталгааны гэрээний бүртгэлийг тухай бүр хөтөлж, тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор энэ журмын 2.6-д заасан этгээдэд хүргүүлнэ.

3.2.Энэ журмын 2.6-д заасан этгээд нь баталгааны нэгдсэн бүртгэлийг хөтөлж, энэ журмын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтын дагуу тайланг иж бүрэн, үнэн зөв гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-д цахимаар хүргүүлнэ.

3.3.Даатгагч баталгааны үйл ажиллагааны тайланг энэ журмын гуравдугаар болон дөрөвдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу улирал бүрийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд цахимаар хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 104 дүгээр тогтоолоор “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж нэмэлт оруулсан./

3.4.Даатгагч болон энэ журмын 2.6-д заасан этгээд баталгааны үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээллийг Хороо шаардсан тохиолдолд тухай бүр хүргүүлнэ.

“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралт

Даатгагчийн баталгааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Хугацаа: ... оны ... дугаар сар

№	Даатгал ын компани	Үүрэг гүйцэтгэгч	Эхлэх огноо	Дуусах огноо	Баталгааны төрөл	Тендерийн дугаар	Төсөв	Тендери йн ангилал	Баталгаа ны дүн	Баталгаа ны шимтгэл	Суурь хураамж	Нийт хураамж	Баталг ааны төлөв	Барьца атай эсэх
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1.	Өмнөх тайлант хугацаанд олгосон бөгөөд хүчинтэй байгаа баталгааны мэдээлэл													
1.1														
1.2														
...														
2.	Тайлант хугацаанд гаргасан нийт баталгааны мэдээлэл													
2.1														
2.2														
...														
	ДҮН													

Маягт нөхөх заавар:

1. “Тайлант хугацаа” гэдэг нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг ойлгоно.
2. Багана “2”-ийг нөхөхдөө “Үүрэг гүйцэтгэгч” гэж баталгаа гаргуулж буй харилцагчийг ойлгоно.
3. Багана “5”-ийг нөхөхдөө “Баталгааны төрөл” гэж тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа, чанарын баталгаа, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгаа болон хуулиар хориглоогүй бусад харилцаанд гаргаж буй баталгааг оруулна.
4. Багана “8”-ийг нөхөхдөө “Баталгааны ангилал” гэж төрийн эсвэл хувийн хэвшлийн худалдан авах ажиллагаанд гаргаж буй эсэхийг ангилан оруулна.
5. Багана “13”-ийг нөхөхдөө “Баталгааны төлөв” гэж тухайн баталгаа идэвхтэй, хугацаа дуусан, цуцалсан эсэхийг ангилан оруулна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(овог нэр)

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр

“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын хоёрдугаар хавсралт

Баталгааны төлбөрийн талаарх мэдээлэл

Хугацаа: ... оны ... дугаар сар

№	Даатгалын компани	Үүрэг гүйцэтгэгч	Баталгаа				Баталгааны төлбөр		
			Баталгааны төрөл	Баталгааны дүн	Эхлэх огноо	Дуусах огноо	Төлбөр төлсөн огноо	Баталгааны төлбөрийн дүн	Үндэслэл
А	1	2	3	4	5	6	8	9	10
1.							
2.									
3.									
...									
	ДҮН								

Маягт нөхөх заавар:

1. Тухайн тайлант хугацаанд төлсөн баталгааны төлбөрийн мэдээллийг оруулна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(овог нэр)

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр

“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын гуравдугаар хавсралт

Маягт СЗХ04171А.Даатгалын компанийн баталгаа гаргах үйл ажиллагааны тайлан

... оны ... дугаар сарын ...-ны өдөр
(тоогоор)

№	Баталгааны төрөл	Нийт гаргасан баталгаа					Хүчинтэй байгаа баталгаа					Баталгааны төлбөр		
		Баталгааны тоо	Баталгааны дүн	Үүнээс: Давхар даатгалд шилжүүлсэн баталгааны дүн	Шимтгэлийн дүн	Үүнээс: Давхар даатгалд шилжүүлсэн шимтгэлийн дүн	Баталгааны тоо	Баталгааны дүн	Үүнээс: Давхар даатгалд шилжүүлсэн баталгааны дүн	Шимтгэлийн дүн	Үүнээс: Давхар даатгалд шилжүүлсэн шимтгэлийн дүн	Төлбөр төлсөн баталгааны тоо	Нийт төлбөрийн дүн	Үүнээс: Давхар даатгагчаас төлсөн төлбөрийн дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Тендерийн баталгаа													
2	Урьдчилгаа төлбөрийн баталгаа													
3	Гүйцэтгэлийн баталгаа													
4	Чанарын баталгаа													
5	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгаа													
6	Бусад баталгаа													
	ДҮН													

Маягт нөхөх заавар:

1. Багана “1”-ээс “5”-д тухайн тайлант хугацаанд гаргасан баталгааны мэдээллийг оруулна.

2. Багана “6”-аас “10”-т баталгаа гаргасан хугацаанаас үл хамааран тухайн тайлант хугацаанд хүчинтэй байгаа нийт баталгааны мэдээллийг оруулна.
3. Багана “11”-ээс “13”-д тухайн тайлант хугацаанд төлсөн баталгааны төлбөрийн мэдээллийг оруулна.

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(овог нэр)

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр

“Даатгагчийн баталгаа гаргах үйл
ажиллагааны журам”-ын дөрөвдүгээр хавсралт

Маягт СЗХ04171Б.Баталгааны нөөц сангийн тайлан

... оны ... дугаар сарын ...-ны өдөр
(тоогоор)

№	Баталгааны төрөл	Мөрийн дугаар	Баталгааны нөөц сан			
			Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
А	Б	В	1	2	3	4
1	Тендерийн баталгаа	1				
2	Урьдчилгаа төлбөрийн баталгаа	2				
3	Гүйцэтгэлийн баталгаа	3				
4	Чанарын баталгаа	4				
5	Ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн баталгаа	5				
6	Бусад баталгаа	6				
	ДҮН	7				

Маягт нөхөх заавар:

1. Багана “2”-т тайлант хугацаанд шинээр байгуулсан баталгааны нөөц сангийн дүнг бичнэ.
2. Багана “3”-т тайлант хугацаанд зарцуулсан нөөц сангийн дүнг бичнэ.

ТАЙЛАН ГАРГАСАН:

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(овог нэр)

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр